



Д.Баярлах, МУБИС-ийн УБТС-ийн хөнгөн атлетик, гимнастикийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)
Г.Батцэцэг, МУБИС-ийн УБТС-ийн хөнгөн атлетик, гимнастикийн тэнхимийн багш, магистр
Б.Нармандах, МУБИС-ийн УБТС-ийн хөнгөн атлетик, гимнастикийн тэнхимийн багш, магистр

ЕБС-ИЙН БАГА АНГИЙН СУРАЛЦАГЧДЫН ГҮЙХ, ХАРАЙХ, ШИДЭХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ АСУУДАЛД

Abstract: The assessment of Physical Education of Elementary school students aims at supporting the development of children's body building and investigating its progress and achievement. The assessment is the index, which expresses the result of teaching. In using different types of assessment, the study will follow the ways to motivate and improve learners' physical culture.

Key words: physical education, assessment, learners, running, jumping and throwing

Манай улсын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нар суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлж ирсэн арвин туршлагатай. Гэвч сургалтын үзэл онол өөрчлөгдөж, суралцагч төвтэй болж эхэлснээр суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийг иж бүрэн байдлаар хянаж үнэлэх болсон учраас үнэлгээний арга барилд суралцах шаардлага гарч ирсэн. Тухайлбал, зөвхөн багш үнэлгээг хийх биш, түүнд суралцагчид оролцож үнэлгээ хамтын шинжтэй болсон. Үнэлгээний үр дүнгээр суралцагчдын мэдлэг, чадварт гарсан ахиц, өөрчлөлтийг судлах боломжтой. Суралцагчийн авсан үнэлгээ нь өөрчлөгдөхгүй гэсэн хуучин ойлголт шинэчлэгдэж, суралцагч өөрөө хичээвэл үнэлгээгээ ахиулах боломжтой болсон нь үнэлгээнд гарч буй өөрчлөлт юм. Суралцагчдыг үнэлэх үнэлгээгээр боловсролын стандартыг дүгнэх, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын орчин, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт, багшийн ажил, сургуулийн үйл ажиллагааг үнэлж сайжруулах боловсролын үр ашгийг тооцох үндэслэл болно¹. Биеийн тамирын хичээлийн үнэлгээ нь бусад хичээлийн үнэлгээнээс зарим талаараа ялгаатай. Биеийн тамирын хуучин стандартад хичээлээр суралцагчдын биеийн чанаруудын хөгжлийн түвшнийг үнэлэхээр тусган хэрэгжүүлж байсан бол одоо үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, хөдөлгөөний чадвар дадал, бие бялдрын бэлтгэлжилтийг харгалзан цогц чадамж бүрийг танин мэдэхүйн түвшинд тодорхой шалгуураар, жишиг даалгавар боловсруулан үнэлэх болсон. Танин мэдэхүйн үйл, үйлдэлтэй сургалтын үр дүн, үнэлгээг холбох арга замыг конструктив таксономи судалдаг. Таксономи taxus-журамлах, бүлэглэх, нэрлэх, nomos-хууль гэсэн утгатай². Биеийн тамирын хичээлээр суралцагчдын эзэмшсэн мэдлэгийг Блумын таксономыг ашиглан үнэлэхдээ сэргээн санах мэдлэгийг, дасгал, хөдөлгөөний талаарх ойлголтыг, хөдөлгөөний талаарх мэдлэгийн хэрэглээг тус тус илрүүлэх жишиг даалгаврыг боловсруулан үнэлнэ. Багш нар суралцагчдын танин мэдэхүйн ба хөдөлгөөний чадварын түвшинд тохируулж үнэлгээний даалгавар боловсруулах үнэлгээний зарчмыг тийм ч сайн баримтлахгүй байгаагаас биеийн тамирын хичээлийн үнэлгээний ач холбогдол буурч, суралцагчдад ойлгомжгүй, хэцүү хүнд санагдах, заримд нь хэтэрхий хялбар санагдах байдал ажиглагддаг.³ Биеийн тамирын хичээлээр судалсан сэдэв, агуулгын хүрээнд тохируулан суралцагчдын нас, хүйс, сэтгэл зүйн онцлог, танин мэдэхүйн болон чадвар дадлын түвшинд тохируулан багш үнэлгээний нормыг боловсруулна. Сургалтын нормыг судалгаанд үндэслэн тогтоох бөгөөд суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан өөр өөр түвшинтэй нормыг боловсруулна. Суралцагчдын биелүүлж буй нормыг өмнөхтэй нь жишиж, ахиц амжилтыг тодорхойлно. Энэ өгүүлэлд зөвхөн 1-5-р ангийн суралцагчдын гүйх, харайх, шидэх чадварыг үнэлэх үнэлгээний талаар авч үзнэ. Бидний боловсруулсан доорх үнэлгээ нь суралцагчдын гүйх, харайх, шидэх чадварын дундаж үзүүлэлт дээр тулгуурлан боловсруулсан нормоор үнэлэх үнэлгээ юм. Гүйх чадварыг үнэлэх судалгаанд нийт 1-5-р ангийн 565 суралцагчид хамрагдсан бөгөөд үнэлгээг математик-статистикийн болон шугаман квадрат хазайлтаар боловсруулсан.

¹ Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 сарын 14 өдрийн А/299 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

² Тамир Л. Үнэлгээний орчин үеийн чиг хандлага. stda.edu.mn/stda/sites/default/files

³ Уртнасан Л. Эрдэм шинжилгээний бичиг 123-126. УБ., 2006

1 дүгээр хүснэгт. 1-3-р ангийн суралцагчдын 15-20 м зайд гүйх чадварыг үнэлэх үнэлгээ

Анги	Тест	Хүйс	Үгэн үнэлгээ			
			Маш сайн	Хангалттай	Сайжирч байна	Анхаарах шаардлагатай
1	15 м	хөвгүүд	4.68 с бага	4.69-5.16 с	5.41-5.17 с	5.42 с их
		охид	4.93 с бага	4.94-6.37 с	7.0-6.38 с	7.1 с их
2	20 м	хөвгүүд	5.27 с бага	5.28-6.63 с	6.64-7.31 с	7.32 с их
		охид	5.98 с бага	5.99-7.04 с	5.77-7.05 с	5.78 с их
3	20 м	хөвгүүд	6.56 с бага	6.57-7.78 с	8.39-7.79 с	8.40 с их
		охид	6.63 с бага	6.64-7.79 с	8.37-7.80 с	8.38 с их

2 дугаар хүснэгт. 4-5-р ангийн суралцагчдын 40-50 м зайд гүйх чадварыг үнэлэх үнэлгээ

Үгэн үнэлгээ			Онц	Сайн	Хангалттай	Дунджаас доогуур	Дэмжлэг хэрэгтэй	Хангалтгүй (онцгой анхаарах)
Анги	Тест	Гүйцэтгэлийн үнэлгээ	85-100	70-84	55-69	40-54	25-39	0-25
4	40 м	Хөвгүүд	7.40 с бага	7.98-7.41	8.56-7.99	9.07-8.57	9.66-9.08	9.67-с их
		Охид	7.69 с бага	8.30-7.70	8.91-8.31	9.52-8.92	10.13-9.53	10.14 с их
5	50 м	Хөвгүүд	5.61 с бага	5.60-7.04	7.03-8.47	8.46-9.90	9.89-11.33	11.34 с их
		Охид	6.82 с бага	6.81-7.92	7.91-9.02	9.01-10.12	10.13-11.22	11.23 с их

Энэ хэсэгт 1-5-р ангийн суралцагчдын харайх чадварыг байрнаас уртад харайх, 10 м зайг дэгдэж туулах, 30 см-ийн өндөртэй тавцан дээрээс хол харайх, 10-12 м зайнаас гүйж уртад харайх чадварыг хөдөлгөөний тестээр судалж үнэлсэн үнэлгээний талаар авч үзнэ. Судалгаанд 1-р ангийн 52 суралцагч, 2-р ангийн 58 суралцагч, 3-р ангийн 56 суралцагч, 4-р ангийн 66 суралцагч, 5-р ангийн 64 суралцагч, нийт 296 суралцагч хамрагдсан.

3 дугаар хүснэгт. 1-3-р ангийн суралцагчдын 10 м зайг дэгдэж туулах чадварыг үнэлэх үнэлгээ

Үгэн үнэлгээ	1-р анги	2-р анги	3-р анги
Маш сайн	11 удаа	9-10 удаа	8-9 удаа
Хангалттай	12 удаа	11-12 удаа	10-11 удаа
Сайжирч байна	13-14 удаа	13-14 удаа	12-13 удаа
Анхаарах шаардлагатай	15 дээш удаа	15-дээш удаа	14 дээш удаа

4 дүгээр хүснэгт 1-3-р ангийн суралцагчдын байрнаас уртад харайх чадварыг үнэлэх үнэлгээ.

Анги	Хүйс	Үгэн үнэлгээ			
		Маш сайн	Хангалттай	Сайжирч байна	Анхаарах шаардлагатай
1-р анги	Хөвгүүд	115- дээш	114-110	109-105	104- доош
	Охид	100- дээш	99-95	94-90	89- доош
2-р анги	Хөвгүүд	120- дээш	119-115	114-110	109- доош
	Охид	115- дээш	114-110	109-105	104- доош
3-р анги	Хөвгүүд	130- дээш	129-122	121-115	114- доош
	Охид	125- дээш	124-118	117-110	109- доош



5 дугаар хүснэгт. 2- р ангийн суралцагчдын 30 см өндөртэй тавцан дээрээс хол харайх чадварыг үнэлэх үнэлгээ

Үгэн үнэлгээ	Маш сайн	Хангалттай	Сайжирч байна	Анхаарах шаардлагатай
хөвгүүд	105- дээш	104- 90	89- 80	79- доош
охид	100- дээш	99- 95	94- 85	84- доош

6 дугаар хүснэгт. 4- р ангийн суралцагчдын 10-12 м зайнаас гүйж уртад харайх чадварыг үнэлэх үнэлгээ

Үгэн үнэлгээ	Онц	Сайн	Хангалттай	Дунджаас доогуур	Дэмжлэг хэрэгтэй	Хангалтгүй (онцгой анхаарах)
Гүйцэтгэлийн хувь	85-100	70-84	55-69	40-54	25-39	0-25
хөвгүүд	240- дээш	239-230	229-220	219-210	209-200	199 доош
охид	210- дээш	209-200	199-190	189-180	179-170	169 доош

7 дугаар хүснэгт. 4- 5-р ангийн суралцагчдын байраас уртад харайх чадварыг үнэлэх үнэлгээ

Анги	Үгэн үнэлгээ	Онц	Сайн	Хангалттай	Дунджаас доогуур	Дэмжлэг хэрэгтэй	Хангалтгүй (онцгой анхаарах)
	Гүйцэтгэлийн хувь	85-100	70-84	55-69	40-54	25-39	0-25
4	хөвгүүд	140- дээш	139-135	134-130	129-125	124-120	119 доош
	охид	135- дээш	134-130	129-125	124-120	119-115	114 доош
5	хөвгүүд	150- дээш	149-145	144-140	139-135	134-130	129 доош
	охид	145- дээш	144-140	139-135	134-130	129-125	124 доош

8 дугаар хүснэгт. 4-5- р ангийн суралцагчдын 10 м зайг дэгдэж туулах чадварыг үнэлэх үнэлгээ

Анги	Үгэн үнэлгээ	Онц	Сайн	Хангалттай	Дунджаас доогуур	Дэмжлэг хэрэгтэй	Хангалтгүй (онцгой анхаарах)
	Гүйцэтгэлийн хувь	85-100	70-84	55-69	40-54	25-39	0-25
4	хөвгүүд	7- удаа	8- удаа	9- удаа	10- удаа	11- удаа	12-оос дээш
	охид	7- удаа	8- удаа	9- удаа	10- удаа	11- удаа	12-оос дээш
5	хөвгүүд	6- удаа	7- удаа	8- удаа	9- удаа	10- удаа	11-ээс дээш
	охид	6- удаа	7- удаа	8- удаа	9- удаа	10- удаа	11-ээс дээш

Бага ангийн суралцагчаар янз бүрийн бөмбөгтэй дасгалуудыг хийлгэснээр цаашид сагсан бөмбөг, волейболын бөмбөг, хөл бөмбөгийн бөмбөгүүдтэй харьцах болон бөмбөгийг барьж авах, бие биедээ дамжуулах, өнхрүүлэх зэрэг чадвартай болно. Мөн алхалт дундаа шидэж дамжуулах, дамжуулалт бүхий хөдөлгөөнт тоглоомоор тоглож чаддаг болно. 1-5-р ангийн 401 суралцагчдын шидэх чадварыг судалж үзэв.

9 дүгээр хүснэгт. 1-5-р ангийн суралцагчдын шидэх чадварыг судлах хөдөлгөөний тест

1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
100 г жинтэй бөмбөгийг байраас мөрний орчмоос нэг гараар хол шидэх	Байраас сагсан бөмбөгийг толгой дээрээс хоёр гараар хол шидэх	Байраас жижиг бөмбөгөөр 7 метрт буй байг шидэж онох	Байраас жижиг бөмбөгөөр 8 метрт буй байг шидэж онох	Байраас сагсан бөмбөгийг доороос хоёр гараар хол шидэх

10 дугаар хүснэгт. 1-р ангийн суралцагчдын 100 г жинтэй бөмбөгийг байраас мөрний орчмоос нэг гараар хол шидэх чадварыг үнэлэх үнэлгээ

Хүйс	Маш сайн	Хангалттай	Сайжирч байна	Анхаарах шаардлагатай
хөвгүүд	2,88-дээш	1,92-2,87	0,96-1,91 м	0,95 м-ээс доош
охид	4,00- дээш	3,06-3,99 м	2,12-3,05 м	2,11-ээс доош

11 дүгээр хүснэгт. 2-р ангийн суралцагчдын байрнаас сагсан бөмбөгийг толгой дээрээс хоёр гараар хол шидэх чадварыг үнэлэх үнэлгээ

Хүйс	Маш сайн	Хангалттай	Сайжирч байна	Анхаарах шаардлагатай
хөвгүүд	4,32-дээш	3,70-4,31	3,08-3,69	3,07-доош
охид	4,53-дээш	3,69-4,52	2,85-3,68	2,84-доош

12 дугаар хүснэгт. 3-р ангийн суралцагчдын байраасаа жижиг бөмбөгөөр 7 метрт буй байг шидэж онох чадварыг үнэлэх үнэлгээ

Маш сайн	Хангалттай	Сайжирч байна	Анхаарах шаардлагатай
3	2	1	Оноогүй бол

13 дугаар хүснэгт. 4-р ангийн суралцагчдын байраасаа жижиг бөмбөгөөр 8 метр буй байг шидэж онох чадварыг үнэлэх үнэлгээ

Үгэн үнэлгээ	Онц	Сайн	Хангалттай	Дунджаас доогуур	Дэмжлэг хэрэгтэй	Хангалтгүй (онцгой анхаарах)
Гүйцэтгэлийн хувь	85-100	70-84	55-69	40-54	25-39	0-25
	5	4	3	2	1	Оноогүй бол

14 дүгээр хүснэгт. 5-р ангийн суралцагчдын байраасаа сагсан бөмбөгийг доороос хоёр гараар хол шидэх чадварыг үнэлэх үнэлгээ

Үгэн үнэлгээ	Онц	Сайн	Хангалттай	Дунджаас доогуур	Дэмжлэг хэрэгтэй	Хангалтгүй (онцгой анхаарах)
Гүйцэтгэлийн хувь	85-100	70-84	55-69	40-54	25-39	0-25
Хөвгүүд	5,54- дээш	5,03-5,53	4,52-5,02	4,01-4,51	4,00-3,50	3,49-доош
Охид	7,20-дээш	5,90-7,10	4,69-5,89	3,48-4,68	3,47-2,27	2,26-доош

ДҮГНЭЛТ, САНАЛ

Багш та бүхнийг дээрх бага ангийн суралцагчдын гүйх, харайх, шидэх чадварыг үнэлэх үнэлгээний жишээнээс санаа авч өөрийн орон нутаг, сургууль, суралцагчдынхаа онцлогт тохируулан үнэлгээ боловсруулан сургалтдаа ашиглана гэдэгт эргэлзэхгүй байна.

1. Судалгаагаар 1-3-р ангийн суралцагчид 20-30 см-ийн өндөрт харайх, 100 см өргөнтэй зурвасыг давж харайх чадвартай, байраас уртад харайх чадвар анги ахих тусам нэмэгдэж байгаа үр дүн гарсан.

2. 4-5-р ангиас суралцагчдын 2 хөлөөр түлхэх чадвар дээшилж байгаа нь өмнөх ангийн суралцагчдыг бодвол ачаалал даах чадвартай болж байна.

3. Судалгаагаар 1-р ангийн суралцагчдын дээд болон доод үзүүлэлтийн зөрүү их байсан нь суралцагчид хөдөлгөөний тестийг сайн ойлгож бүх хүчээр гүйцэтгээгүй чадаагүй байж болох талтай.

4. Сагсны бөмбөгийг толгой дээрээс болон доороос хол шидэх чадвараар 2-р ангийн хувьд охид, хөвгүүдийн дундаж үзүүлэлт ойролцоо байна.

5. Бай онох шидэлтэд охидын 66% нь хөвгүүдийн 50% нь байг онож чадаагүй ба 1 оноо авсан суралцагчид 37%-ийг эзэлж байна. Тиймээс хичээлийн хөтөлбөрт бай онох болон шидэлтийн дасгалыг түлхүү оруулж хичээллүүлэх нь зүйтэй байна.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Боловсролын хүрээлэн. (2010). *Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын сургалтын агуулгын хүрээ*. Улаанбаатар

Боловсрол шинжлэх ухааны яам. (2013). *Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам*. Улаанбаатар

Уртнасан, Л. (2006) *Эрдэм шинжилгээний бичиг* (123-126). Улаанбаатар

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам. (2013.08.14). *Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам*. А/299 тушаалын 1 дүгээр хавсралт

Тамир, Л. Үнэлгээний орчин үеийн чиг хандлага. [Std.edu.mn/stda/sites/default/files/](http://stda.edu.mn/stda/sites/default/files/)